

**“Оюуны индэр” эрдэм шинжилгээний хурлын шилдэг  
илтгэлүүд**

**“ХОРИХ ЯЛААР ШИЙТГЭГДСЭН ӨСВӨР НАСНЫ ХОРИГДЛЫН  
ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ”**

**“CONCERNING PROBLEMS THAT THE RIGHTS OF JUVENILE  
PRISONERS SENTENCED BY PRISON”**



**Б.Азжаргал**

541 дүгээр дамжааны дэд түрүүч



**Б.Булган**

541 дүгээр дамжааны сонсогч

**Товч агуулга:** Өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдолд ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг эрэлхийлэхэд оршино.

**Abstract:** *It is to study the issues that arise in the process of criminal liability for juvenile prisoners who are serving prison terms.*

**Түлхүүр үг:** Ял, өсвөр насны хоригдол, хорих ял,

**Keywords:** *Penalty, juvenile prisoner, imprisonment*

Хүн төрсөн цагаасаа эхлэн бүхэл амьдралынхаа туршид бие махбод, сэтгэл зүйн хувьд хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд хамгийн их өөрчлөгддөг эмзэг үе нь өсвөр нас байдаг билээ. Энэхүү өсвөр насны өөрчлөлтийн үед хүүхэд<sup>27</sup> нь хоёр том асуудалтай тулгардаг. Үүнд:

---

<sup>27</sup> Хүүхдийн Эрхийн конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд” гэнэ.

1. Би үзэл баримтлал- Үе тэнгийнхнийхээ дунд зохих байр суурь эзлэх, нэр хүндтэй байх, нэг талаас бусадтай адил байх, нөгөө талаас тэд нараас ялгарах хүсэл тэмүүлэл, түүгээрээ гайхуулах, бахархах хандлага.

2. Эцэг эх, асран хамгаалагчаас хараат бус байх- Өөрийгөө том хүн боллоо хэмээн бодож, насанд хүрсэн хүний байр сууринаас аливаад хандахыг хичээдэг. Үүнээсээ болон эцэг эхтэйгээ зөрчилддөг.

Дээрх 2 асуудлаас үүдэлтэйгээр өсвөр насны хүүхэд гэмт хэрэгт холбогдох, гэмт хэрэг үйлдэж, нийгэм болон хүнд хор хохирол учруулах эрсдэлийг бий болгож байдаг.

Нөгөөтэйгээр сүүлийн жилүүдэд манай улсад нийгмийн сөрөг хүчин зүйлүүд болох ажилгүйдэл, архидалт, гэр бүл салалт, эцэг, эхийн хараа хяналтгүй болон хохирогчдын биеэ хамгаалах чадваргүй байдал нь гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа үндсэн шалтгаан болж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын гэр бүлийн байдлыг авч үзвэл, бүтэн өнчин-3, өргөмөл-1, хагас өнчин-8, хойд эцэг эхтэй-4, эцэг эх салсан-4, төрсөн эцэг эхтэй-16 хоригдол байна. (хавсралтаас №1-ээс үзнэ үү). Үүнээс үзэхэд нийт ял эдэлж байгаа хоригдлуудын 55.6 хувь нь ар гэрийн асуудалтай байгаа нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн байж болзошгүй нь харагдаж байна.

Монгол улс 1960 онд НҮБ-д нэгдэн орж, Олон улсын гэрээ конвенцид заасан дүрэм журмын дагуу аливаа үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээснийхээ хүрээнд 1990 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн конвенцид нэгдэн орсон байдаг. Тус конвенцийн 37-р зүйлд зааснаар:

Оролцогч улсууд нь:

(а) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх;

(b) хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх;

(c) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрд насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана. Дээд ашиг сонирхолд нь харшилна гэж үзээгүй бол эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрийг насанд хүрэгчдээс тусгаарлах, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд гэр бүлтэйгээ харилцаатай байх, уулзах боломжоор хангах;


(d) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад зохих туслалцааг даруй авах, түүнчлэн эрх чөлөөгөө хасуулсан нь хуулийн үндэслэлтэй эсэхийг шүүх буюу эрх бүхий хараат бус, аль нэг талын эрх

ашигт үйлчлэхгүй байгууллагаар тогтоолгох, шуурхай шийдвэрлүүлэх эрхтэй.

Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулинд гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ <sup>28</sup> гэж хуульчилсан байдаг.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.



Нийтэд тустай ажил хийлгэх ял: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна. Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.

Зорчих эрхийг хязгаарлах ял: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял 120-360 цаг оногдуулна.

<sup>28</sup> Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016. №07

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих: Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд /18/ хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас /21/ хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны 1 дүгээр сард 1435 болж, өмнөх оны мөн үеэс 763 (2.1 дахин)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 45 (3.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 170 (11.8%) нь эмэгтэйчүүд байна.<sup>29</sup> (Хавсралт№2-аас үзнэ үү). Жилээс жилд 18 хүртэлх насны хүүхэд гэмт хэрэгт холбогдох нь ихэсч байгаа бөгөөд үүнээс гэмт хэрэгт холбогдсон энэ насны хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамааран эрүүгийн хариуцлагыг оногдуулж байна.

Өсвөр насны хүнд ихэвчлэн хорихоос өөр төрлийн ял болон тэнсэх, ял хойшлуулах арга хэмжээг авдаг боловч үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамааран зарим тохиолдолд хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг.

2022 оны байдлаар хорих ялаар шийтгэгдсэн өсвөр насны хоригдлуудыг гэмт хэргийн зүйлчлэлээр нь судлан авч үзвэл ЭХТА-д заасан 10.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 1, 11.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 2, 12.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 24, 17.1-д заасан гэмт хэрэгт шийтгүүлсэн 6, 17.2-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 3, нийт 36 хоригдол ШШГЕГ-ын харъяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байна. (Хавсралт№3-аас үзнэ үү)

1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд анх Хүмүүжил-Хөдөлмөрийн колонид 18 нас хүрээгүй хоригдлыг хүмүүжүүлнэ гэж заасан бөгөөд энэ нь өсвөр насны хүнд оногдуулж буй ялыг эдлүүлэх нөхцөл журмыг тусгайлан заасны хэлбэр юм. Ийнхүү хуулийн

<sup>29</sup><https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=4.%20Crime%202022%201%20mgl.pdf&ln=Mn>

шинэчлэлийн хүрээнд Хүүхдийн хорих 411 дүгээр анги нь Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага хэмээн нэршлийн болон чиг үүргийн хувьд өөрчлөгдсөн. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын нэг онцлог нь тусгай сургуультай, хоригдол хүүхдүүдэд ЕБС-ийн хөтөлбөрөөр хичээл зааж, боловсрол эзэмшүүлдэг.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь нэг талаас ШШГБайгууллага буюу хорих байгууллага, нөгөө талаас Боловсрол, шинжлэх ухааны яамны харъяа Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургууль гэсэн хоёр өөр чиг үүрэг бүхий байгууллагын нэгдэл юм. Энэхүү байгууллага нь ерөнхий боловсролын мэдлэг олгож, өсвөр насны хоригдлуудыг сурган хүмүүжүүлэх замаар нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ давамгайлан биелүүлэх шаардлагатай. Гэтэл одоогийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих ангийн нэгэн адил хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний дагуу хорих ял эдлүүлж буй нөхцөл байдал нь бусад хорих ангиас ялгарах зүйлгүй байна. Сурган хүмүүжүүлэх тусгай байгууллага гэдэг үг зүйн утгаараа хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудад хорих ангид хоригдож буй мэт мэдрэмж төрүүлэхгүй байх нь чухал шаардлагатай. Хорих ангид байгаа мэт мэдрэмж төрүүлж байгаа нь насанд хүрсэн хүн, өсвөр насны хүн хоёрын ял эдлүүлэхэд ялгаатай ойлголт байхгүй байна.

Мөн энэ байгууллагын үйл ажиллагаа явуулж буй байр нь ашиглалтын шаардлага хангахгүйн улмаас хүний эрх тэр дундаа хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл үүсээд байна. Тухайлбал, тус байрны хана цуурсан, нурсан, суулт өгсөн, газрын гадаргын ус ихтэй, хөрсний хөлдөлт явагддаг тул засвар хийгээд нэмэргүй нөхцөлд байна. Ийм орчин нөхцөлд хүмүүжиж байгаа хүүхдүүд болон тус байгууллагын ажилтан албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байна. Цаашлаад энэ байдал хоол хүнс болон агааржуулалт зэрэгт нөлөөлөх эрсдэлтэй билээ.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын одоо ашиглаж буй гурван барилга нь 1978 онд цэргийн казармын зориулалтаар ашиглалтад оржээ. 40 гаруй жилийг элээсэн тус барилгуудыг хорих 431 дүгээр анги ашиглаж байсан бөгөөд 2012 онд мэргэжлийн хяналтын байцаагчийн 07-208/638, 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02-03-084/818 тоот дугаартай дүгнэлтээр хүн ажиллаж, амьдрах боломжгүй, ашиглалтыг зогсоох тухай дүгнэлтүүд ирүүлж байсан. Гэтэл нурах шахсан өнөө барилгуудыг 2017 оны Засгийн газар, ШШГЕГ-ын шийдвэрээр Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад шилжүүлэн өгч, нүүж орсон.

Улмаар нөхцөл байдал хүндэрч 2020 оны наймдугаар сард Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран өсвөр насны хоригдлуудын сурдаг, амьдардаг байруудыг нарийвчлан шалгасан. Гэтэл тус хорих ангийн барилгууд нь

бүхэлдээ хэзээ мөдгүй нурах бүх “болзол”-ыг хангасан болох нь дахин тогтоогдсон байна.

Тухайлбал, хоригдлын I байр буюу Ерөнхий боловсролын 110 дугаар сургуулийн байр, II байр буюу гал тогоо, халуус ус, ариун цэврийн өрөө, аж ахуйн хоригдлын байр, III байр буюу авто гражад шалгалт хийхэд дээрх барилгуудын үндсэн хийцэд их хэмжээний эвдрэл, гэмтэл гарсан, хөрсний овойлт, суултаас шалтгаалан нэгдүгээр давхрын шал нь хотойж суулт өгсөн, бетон хаяавчнууд нь хагарсан, агааржуулалтын хоолойнууд нь бөглөрсөн, гадна дотор хананд их хэмжээний нэвт хагарал цууралт, суулт өгсөн, хөрсний ус их хэмжээгээр нэвчдэг болсон нь тогтоогдсон. Мөн хамгийн ноцтой нь тус барилга газар хөдлөлтийн чичирхийлэл болон механик үйлчлэл буюу доргилтод бүхэлдээ нурах нөхцөл бүрдсэн байгааг тогтоосон байна.

Өсвөр насны хоригдлууд хэзээ мөдгүй нурах шахсан барилгад хоригдож байгаа нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан Монгол улсын иргэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 209 дүгээр зүйлд заасан “Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байх” шаардлага хангахгүй, НҮБ-ын 1955 оны I их хурлаар батлагдсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-ийн 10, 11 дүгээр зүйлүүдийг тус тус зөрчсөн буюу өсвөр насны хоригдлуудын эрх ноцтой зөрчигдсөөр байна.

Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагдаж, чөлөөтэй зорчих эрх нь хязгаарлагдаж буй хэдий ч тэдгээр өсвөр насны хүүхдүүдийн Монгол улсын Үндсэн хуульд заасан бусад эрх ямар нэгэн байдлаар зөрчигдөх ёсгүй билээ.

Мөн хууль тогтоомжийн уялдаа холбоо муу байгаагаас хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудлыг анхаарах шаардлагатай байна. Хорих ангийн дотоод журам, бусад эрх зүйн актуудыг Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэхэд зарим талаар эрх зүйн хийдэл гарч, практик нөхцөл байдалтай зөрчилддөг. Тухайлбал, Хорих ангийн дотоод журмын 7 дугаар зүйлд заасан Хоригдолд зөвшөөрөгдөх эд зүйлсийн жагсаалтад ЕБС-д суралцаж буй хоригдлын хичээл хийхтэй холбоотой хичээлийн хэрэглэгдэхүүн бусад шаардлагатай зүйлсүүдийг тусгайлан тусгаж өгөөгүй нь энэ журмыг зөрчих үндэслэл болж байна.

Мөн ШШГТХуулийн 239 дүгээр зүйлд зааснаар нээлттэй хорих ангид хоригдож буй хоригдолд тодорхой нөхцөл, шалтгаан үүссэний улмаас 7 хүртэлх хоногийн чөлөө олгож болох тухай хуульчилсан байдаг. Гэтэл Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих ангийн адил дэглэм, зэрэглэлээр хуваагддаггүй тул өсвөр насны хоригдлуудад

зайлшгүй шаардлагатай тодорхой нөхцөл байдал үүссэн бол чөлөө олгох талаар ямар нэгэн хуулийн зохицуулалт байхгүй байна.

Хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын гэр бүлийн байдал тогтворгүй, анхаарал халамж сул, амьжиргааны түвшин доогуур зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж өсвөр насны хоригдлуудад сурагчийн хувцас, хичээлийн хэрэгслийг авч өгөх боломжгүй тул сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичгийг хамтран ажилладаг төрийн бус байгууллага болон сайн үйлсийн тусламж хандиваар шийдвэрлэдэг.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож ял эдэлж байгаа боловч нөгөөтэйгүүр боловсрол эзэмшиж нийгэмшиж байгаа сурагч тул Хоригдол гэсэн нэр томъёо нь утга агуулгын хувьд ч оновчгүй нэршил юм.

### **Дүгнэлт, санал**

Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа нь бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаанаас илүү онцлогтой юм. Учир нь аливаа хүн өсвөр насандаа цаашдын амьдралын төлөвшлийг олж авдаг бөгөөд ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын хувьд дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зөв үзэл хандлагыг төлөвшүүлэх нь нэн чухал.

Мөн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа нь уян хатан, хүний эрхийн мэдрэмжтэй байхыг шаарддаг тул төрөөс энэ төрлийн ажиллагаанд ихээхэн анхаарч, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх илтгэлтэй холбогдуулан дараах саналыг дэвшүүлж байна.

#### **Хууль, эрх зүйн чиглэлээр:**

➤ Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад мөрдөх дотоод журмыг тусгайлан тогтоох

➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны хоригдлын чөлөө олгох асуудлыг тодорхой тусгах

#### **Төсөв, санхүүгийн чиглэлээр:**

➤ Хичээлийн сурах бичиг, сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах зардлыг улсын төсөвт жил бүр суулгах

#### **Барилга байгууламжийн талаар:**


➤ Цэвэр, бохир, дулааны шугамд холбогдсон байршилд шинэ барилга байгууламж барих (Хорих ангийн өрөөний стандартаар бус бусад ЕБС-ийн жишгээр адил зохион байгуулалттай байх)

➤ Сургалтын анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх

➤ Сургуулийн бүс, хоригдлын амьдралын бүсээр ялган зааглах


### Хавсралт №1

Гэмт хэргийн зүйл заалтаар нь:




### Хавсралт №2

Гэмт хэрэгт холбогдогч яллагдагч /насны бүлгээр/



## Хавсралт №3



**Ашигласан материалын жагсаалт**

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01
2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2002. №05
3. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016. №07
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017. №24
5. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги УБ., 2002 он
6. Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ., 2021 он
7. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012 он
8. <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=4.%20Crime%202022%20I%20mal.pdf&ln=Mn>
9. [www.1212.mn](http://www.1212.mn)
10. <https://www.ulsturch.mn/article/52302>
11. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц
12. <https://blog.ipleaders.in/procedure-in-relation-to-children-in-conflict-with-law-under-the-juvenile-justice-act/>
13. <https://archive.crin.org/en/home/ages/asia.html>